

“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2017 оны 03 сарын 11-ний өдөр

№ 1.

Дархан-уул аймаг

“Дархан Нэхий” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг Дархан нэхий ХК-ийн хурлын зааланд 2017 оны 03-р сарын 11-ний өдрийн 14⁰⁰ цагт Хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн тоо 871357 ширхэг, буюу 78,8%-ийн ирцтэй байсныг хангалттай гэж үзэж хурлыг хийв.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

1. Э. Батсайхан	326903ш	9. М. Оюунчимэг	10ш
2. Р. Сүмбэнхүү	301008ш	10. Б. Чанцал	2341ш
3. Б. Түвшин	165100ш	11. С. Хулан	1001ш
4. Б. Дагвацэрмаа	29087ш	12. Би ди сек ХХК /төлөөлөл/	34ш
5. С. Норжмаа	2811ш	13. Дархан нэхий ХК	6155ш
6. Д. Батжаргал	10803ш	14. Дархан импорт энд импорт ХХК	882ш
7. Х. Золжаргал	17213ш	15. Улзын донж ХХК /төлөөлөл/	69ш
8. Б. Гэрэлмаа	7800ш	16. Дорнын хөх сувд ХХК /төлөөлөл/	140ш

Зохион байгуулалтын асуудал хэлэлцэв.

Хурлын даргаар Дархан нэхий ХК-ийн ТУЗ-ийн дарга Р. Сүмбэнхүүг, тооллогын комиссын даргаар иргэн М. Оюунчимэгийг тус тус ажиллуулахаар боллоо.

Мөн уг хурлаар хэлэлцэх асуудлыг, асуудал тус бүрээр хэлэлцсэний эцэст хувьцаа эзэмшигчид батлагдсан саналын хуудсаар саналаа өгч, тооллогын комисс эцсийн шийдвэрийг гарган дүнг танилцуулахаар болов.

Ингээд хурлын дарга Р. Сүмбэнхүү доорхи 5 хэлэлцэх асуудлыг танилцуулав.

- Хэлэлцэх асуудал:
1. Компанийн 2016 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн гүйцэтгэлийг дүгнэсэн ТУЗ-ийн дүгнэлт,
 2. Аудиторын дүгнэлт, ТУЗ-ийн аудитын хорооны 2016 оны тайлан, дүгнэлт
 3. Хөндлөнгийн аудитын байгууллага сонгох, аудитор томилох
 4. ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт, ТУЗ-ийн төсөв батлах
 5. Ноогдол ашиг хуваарилах тухай

Хэлэлцсэн нь:

Р. Сүмбэнхүү

- Дархан нэхий ХК-ийн хувьцааны тархалтын судалгааны талаар товч мэдээллийг өглөө. Тус компани нь 1105479ш хувьцаатай. Өнөөдрийн хуралд хувьцаа эзэмшигч болон хувьцаа эзэмшигчийн төлөөлөл ирсэн байна. Би Ди Сек ХХК-аас төлөөлөгч ирсэн байна.

1. компанийн засаглалын талаар товч танилцуулъя. Тус компанийн ТУЗ 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж ирлээ. ТУЗ-ийн 9 гишүүнтэй, үүнээс 3 хараат бус, 6 хараат гишүүд, мөн ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга гэсэн бүтэц бүрэлдэхүүнтэй 3 хороотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирлээ. Нийт 10 удаагийн хуралдаанаас 25 төрлийн шийдвэр гаргажээ. Тус компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагууд нь СЗХ, ҮЦҮТ, Хөрөнгийн бирж, КЗҮТ зэрэг байгууллагуудаас өгсөн зөвлөмж, шинээр гаргасан дүрэм, журмуудыг судлаж ажил үйлчилгээндээ мөрдөж хэвшүүлэх, компанийн засаглалын ил тод байдлыг эрхэм зорилго болгон ажиллах шаардлага тулгарч байгааг мэдэрч, сайн засаглалтай компани болохын төлөө хичээн ажиллаж ирлээ. 2015 онд тус компанийн хувьцааг 3816 хүн, 2016 оны бүртгэлээр 3708, 2017 оны 02 сарын 10-ны бүртгэлээр 3628 хүн тус тус эзэмшиж, эзэмшигчийн тоо сүүлийн жилд 80 хүнээр цөөрсөн байна. ХЭ-ийн тоог багцлан харьцуулалт хийснийг танилцуулав. 10000ш-ээс дээш хувьцаа эзэмшигчийн тоо нэгээр нэмэгдсэн байгааг харвал хувьцааны тархалт бөөгнөрөх талдаа байгаа гэсэн дүгнэлттэй.

2. Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн гүйцэтгэлийн тайланг ТУЗ дээр хэлэлцэж хангалттай гэсэн дүгнэлт өгснийг батлуулахаар хэлэлцүүлж байгаа тул уг тайлангаас товч танилцуулъя.

Дархан нэхий ХК нь 2015 онд 317 ажиллагсадтай ажиллаж байсан бол 2016 онд мөн 416 орчим хүнтэй ажилласан байна. Компанийн бүтэц зохион байгуулалтын хувьд оны эхэнд батлагдсан салбар, нэгжийн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулсан. Салбар нэгж болгон бие даасан төсөв, төлөвлөгөөг боловсруулж, зардлаа нарийн тооцож, тодорхой үр бүтээлтэй, тодорхой чиглэлтэй, хариуцлага хүлээх чадвар бүхий баг болон ажиллаж ирсэн байна. /Тайланг хавсаргав/. Ерөнхийдөө үйл ажиллагааны үр дүнг хэлэхэд улс орны эдийн засаг хямралтай хүнд хэцүү үед сайн ажилласан гэж үзэж байна

Ололт, давуу талууд:

-Ашиглалтад хамаарах зардлын хяналтыг сайжруулахын тулд нэгж хэсгийг тоолууржуулж, зардлыг тодорхой тооцож чадсан
-Хөдөө орон нутагт түүхий эдийг газар дээрээс нь худалдан авах, өөрийн барилга байгууламж, түүхий эдийн төвүүдийг барьж, Архангай, Хөвсгөл аймагт нэрийн барааны бөөний худалдааны дэлгүүр нээсэн
-Уур үйлдвэрлэх дарлалт зуухтай болсон нь дулааны улиралд уур ашиглах бүрэн боломжтой
-Борлуулалтыг нэмэгдүүлэхийн тулд хямд үнээр зах зээлд гарч агуулахын барааны үлдэгдлийг багасгаж, худалдан авагчдыг татах бодит хөшүүрэг болсон байна.
-Арьс ширний үйлдвэрүүдэд хэрэглэдэг химийн материалын борлуулалтыг хийж эхэлж байна.

Цаашид хүндрэл гарч болзошгүй асуудлууд:

1. Арьс ширний түүхийгээр нь экспортлох засгийн газраас гаргасан шийдвэр нь түүхий эдийн бэлтгэл тасалдахад хүрч байна.
2. Хонины нэхийний үнэ хэдийгээр хямдарсан боловч иргэд арьс шир хамгаалах ямарч ажил хийхгүй үнэгүйдүүлэн хаяж байна
3. Гадаад захиалга буурсан /түүхий эд экспортлох/
4. Цаг үе эдийн засгийн байдал, Импликацийн түвшин өсч хүндэрвэл 2017 онд графикийн дагуу төлөх зээл, зээлийн хүү 4,38 тэрбум төгрөг төлөлтөд хүндрэл учирч магадгүй байна
5. Эсгий үйлдвэрлэл ашиггүй болоод тээврийн хөлс зардал өндөр борлуулалт муудаад 2016 онд эсгийний үйлдвэр ажиллаагүй
6. Цахилгаан эрчим хүч, уур усны үнэ тариф нэмэгдээд байна.
7. Эрхтэд мал аж ахуй, хадлан бордоо, газар тариалан, үнэг туулай үржүүлэхээр "Нэхий –Агр компани байгуулан ажилласан боловч эдийн засгийн хүндрэл, хямралын үед ашиггүй ажиллаж бүх үйл ажиллагааг зогсоосон
8. Валютын ханш тогтворгүй байнга өсөлттэй байгаа
9. Дотооддоо бараа худалдан авах чадвар болон борлуулалт муудсан
10. 2017 онд төр засгийн бодлогоор төрөл бүрийн татварын ноогдуулалтад өөрчлөлт орох шийдвэр гараад байна. Эхний ээлжинд НДШ-ийг 2% -иар нэмэгдүүлэхээр 2017 оны 04 сарын 01-ны өдрөөс хэрэгжүүлэх болсон гэх мэтээр татвар шимтгэл нэмэгдэхээс биш хасагдах асуудал байхгүй байна.
11. Эдийн засгийн хүндрэл, хямралын үед төлөвлөлт хийхэд хүртэл цаг үеийн байдлыг харгалзан хүлээлт бий болж, цаг хугацаа алдах, эрсдэл учрах зэрэг хүндрэл гарч болзошгүй гэсэн дүгнэлт гаргаж байна.

Дээрхи хүндрэлүүдээс дүгнэж үзэхэд өр нь цаашид компаний эдийн засаг, үйл ажиллагааны явцад эрсдэл хүндрэл гарч болзошгүй гэж үзэж байна.

Энэхүү хэлэлцүүлж буй асуудлаар асууж тодруулах зүйл байна уу гэж ХЭ-дээс асуув.

Р. Сүмбэнхүү

-За өөр асуулт байхгүй бол 1-р асуудлыг дуусгаж дараагийн асуудалд орёё.

Дархан нэхий ХК-ний аудитын хорооны 2016 оны тайланг ТУЗ-ийн гишүүн, аудитын хорооны гишүүн Б. Түвшин уншиж танилцууллаа. /Тайланг хавсаргав/. Аудитын хороо 4 хүн томилон ажиллуулж аль болох эерэгээр дүгнэлт хийсэн.

-Аудитын шалгалтыг 3 үндсэн чиглэлээр хийлээ. 1. Эрх зүйн баримт бичигт, 2. Санхүүгийн, 3. Барилгын

-Санхүүгийн хувьд 2015 оны эцсийн, 2016 оны эхний үлдэгдэл зөрүүтэй байсан. Мөн зарим авлагыг дутуу тайлагнаснаас эрсдэлд орж болзошгүй. Аудитын дүгнэлтийг дэлгэрэнгүй урьдчилан танилцуулсан байгаа. Цаашид дүгнэлтэд тусгагдсан зүйлсийг засаж залруулж ажлаа сайжруулах хэрэгтэй гэж зөвлөж байна.

-эрх зүйн бичиг баримтын зөрчилдөөнийг арилгах, компаний болон охин компанийн дүрмийг шинэчлэн найруулах шаардлагатай. ТУЗ-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, ТУЗ-ийн эрх 33-д шилжсэнтэй холбоотой ТУЗ-тэй эн зэрэгцэхүйц эрх зүйн баримт бичиг гаргаж байх хэрэгтэй. Эрх шилжүүлсэн дүрмийн нэмэлтэд захирлын зөвлөлд хариуцлага тооцох нь тодорхойгүй байна. Тусгах, 33-ийн хурлын тэмдэглэл хөтлөх 33-д нарийн бичиг ажиллуулах.

-Барилгын ажил сайн байлаа. Угсралт сайн. Цаашид зорийн давхрыг зэврэлтээс хамгаалахыг зөвлөв.

Удирдлагын зүгээс зарим хэсэгт үйл ажиллагааг хянаж үр дүнтэй ажиллуулдаг боловч зарим хэсэгт хяналт тавьж хүрэлцдэггүй. Дүрмийг засаглалын кодекс, компанийн хуулийн дагуу өөрчлөх, захирлын зөвлөл хувьцаа эзэмшигчдэд хохиролтой буруу шийдвэр гаргахад 33-д хүлээлгэх хариуцлага тодорхойгүй байгааг анхаарах

Б. Энхбаяр /Увжийн донж ХХК-ийн төлөөлөл/

- Борлуулалт бүгд нэгдсэн байна уу. Нэхийгийн борлуулалтыг гэж үзэж болох уу.

Р. Сүмбэнхүү

-Бүгд нэгдсэн байгаа. Зөвхөн Ижий трейд тусдаа тусгагдсан

Э. Батсайхан

-13 тэрбумын борлуулалтаас нэхий бүтээгдэхүүн, дээлний борлуулалт 10 тэрбум хийгдсэн байгаа.

Б. Энхбаяр /Увжийн донж ХХК-ийн төлөөлөл/

-Балансаар ашиг өндөр харагдаж байдаг. Бид Дорнодоос зорьж ирлээ. Тайлангаас өөр асуух, хэлэх зүйл алга

Р. Сүмбэнхүү

-Өөр асуух зүйл байна уу.

Б. Энхбаяр /Увжийн донж ХХК-ийн төлөөлөл/

-Хөдөөд хонины арьс үнэгүйдэж байна. Хоньчинд мөнгө өгөөд ноосыг нь аваад арьсыг шууд булж байна./үнэ хүрэхгүй учраас ийм үйлдэл хийгдэж байна/

Р. Сүмбэнхүү дараагийн асуудлаар: Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгож, гэрээ байгуулан хамтран ажиллахаар Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй "Далайван аудит" компанийн, бүрэлдэхүүн, үйл ажиллагаа, тусгай зөвшөөрөл, ажлын туршлага, талаар танилцуулж, хэлцүүлэв.

Д. Батжаргал

- Яагаад 1 байгууллагыг танилцуулж байгаа юм бэ. Өөр судлагдсан байгууллага байхгүй юм уу. Аудитын байгууллага чадвартай байвал сайн.

Х. Золжаргал

- далай ванг яагаад сонгосон бэ?

Э. Батсайхан

- ТУЗ-ийн тайланг сонслоо. Тайлан гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан ч юм шиг, ТУЗ-ийнх ч юм шиг холилдсон байна. Цаашид ТУЗ-ийн тайланг дүгнэлт байдлаар хийх нь зүйтэй.

-ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг чанаржуулъя гэж бодож байна. Хууль эрхийн мэргэжлийн болон чадварлаг бүрэлдэхүүнийг бий болгох хэрэгтэй.

- Энэ жилийн дотоод аудит сайн ажилласан. Компанид тус дэмтэй ажиллаж ирсэн гэж үзэж байна. Аудитын хороо нь дотоод хяналтыг сайн хийж, бодитой, зөв зүйтэй дүгнэлт гаргажээ гэж үзэж байна.

Р. Сүмбэнхүү дараагийн асуудалд орёе.

-ТУЗ-ийн бүтэц өөрчлөх санал орж ирээгүй тул өмнө ажиллаж байсан гишүүдийг дахин нэр дэвшүүлж байна. ТУЗ нь 9 гишүүнтэй. Хараат-6, хараат бус 3, нарийн бичгийн дарга -1, ТУЗ-ийн дарга -1 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж ирсэн. Төсөв орон тоог хэвээр нь ажиллуулах, төсвийг өмнөх оныхтой нэгэн адил 82 сая төгрөгөөр санал оруулж байна. Дэлгэрэнгүй төсвийг хавсаргав.

Энэ асуудлаар тодорхой асуулга гараагүй тул дараагийн асуудлыг хэлэлцээд:

Хуралд оролцогчид ноогдол ашиг хуваарилах талаар хэсэг ярилцаад, Эдийн засгийн хямрал, тус компанийн санхүүгийн үйл ажиллагаа, Банкны зээлтэй байгаатай холбогдуулж ноогдол ашиг хуваарилахгүй байх нь зүйтэй гэж үзлээ.

Хэлэлцэх асуудал дууссан тул саналын хуудсаар санал авахаар тооллогын комисс ажиллалаа. Саналаа өгөөд хурал хэсэг завсарлаж дахин хурлаа эхлэн тооллогын комиссын дүнг сонсов.

Саналын хуудсыг тооллогын комисс хураан авч гарсан дүнг танилцуулж, тооллогын комиссын №01, №02, №03 тоот шийдвэрийг тус бүрийг тооллогын комиссын дарга М. Оюунчимэг уншиж танилцууллаа.

Санал хураалтаар доорхи 9 гишүүнийг үргэлжлүүлэн ТУЗ-ийн гишүүнээр ажиллуулахаар, үүнээс хараат бус гишүүнээр 3 гишүүн ажиллахаар болов. Үүнд:

1. ТУЗ-ийн хараат гишүүдээр:

1. Эрдэнэдалайн Батсайхан /Хуралд оролцогчдын 100%-ийн саналаар буюу нийт хувьцааны 78,8 %-аар/
2. Равжаагийн Сүмбэнхүү /Хуралд оролцогчдын 100%-ийн саналаар буюу нийт хувьцааны 78,8 %-аар/
3. Банзрагчийн Түвшин /Хуралд оролцогчдын 100%-ийн саналаар буюу нийт хувьцааны 78,8 %-аар/
4. Далхжавын Батжаргал /Хуралд оролцогчдын 100%-ийн саналаар буюу нийт хувьцааны 78,8 %-аар/
5. Хумбагайн Золжаргал /Хуралд оролцогчдын 100%-ийн саналаар буюу нийт хувьцааны 78,8 %-аар/
6. Баасангийн Гэрэлмаа /Хуралд оролцогчдын 100%-ийн саналаар буюу нийт хувьцааны 78,8 %-аар/

2. ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр

7. Шаравжамцын Мөнгөндүүлга /Хуралд оролцогчдын 100%-ийн саналаар буюу нийт хувьцааны 78,8 %-аар/
8. Самбуугийн Мэндхүү /Хуралд оролцогчдын 100%-ийн саналаар буюу нийт хувьцааны 78,8 %-аар/
9. Жадамбаагийн Баярсайхан /Хуралд оролцогчдын 100%-ийн саналаар буюу нийт хувьцааны 78,8%-аар/

2. Хороодын дарга, гишүүдийг дор зааснаар сонгохоор хэлэлцэж шийдвэрлэв.

а. Аудитын хорооны даргад:

Жадамбаагийн Баярсайхан /Хуралд оролцогчдын 100%-ийн саналаар/

Гишүүдэд:

Банзрагчийн Түвшин /Хуралд оролцогчдын 100%-ийн саналаар/

Шаравжамцын Мөнгөндүүлга /Хуралд оролцогчдын 100%-ийн саналаар/

Самбуугийн Мэндхүү /Хуралд оролцогчдын 100%-ийн саналаар/

б. Цалин, хөлс урамшуулал, нэр дэвшүүлэх хороог нэгтгэж, хорооны даргад:

Равжаагийн Сүмбэнхүүг /Хуралд оролцогчдын 100%-ийн саналаар/

Гишүүдэд:

Жадамбаагийн Баярсайхан /Хуралд оролцогчдын 100%-ийн саналаар/

Шаравжамцын Мөнгөндүүлга /Хуралд оролцогчдын 100%-ийн саналаар/

Самбуугийн Мэндхүү /Хуралд оролцогчдын 100%-ийн саналаар/

ТУЗ-ийн төсөв, цалин урамшууллыг оруулж ирсэн саналаар батлахаар болов. Хурлаар хэлэлцсэн асуудал тус бүрээр санал авч, гарсан дүнг тооллогын комиссын дарга М. Оюунчимэг дэлгэрэнгүй танилцууллаа.

Компаний хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаас хуралд оролцогчдын 100%-н саналаар дараах шийдвэрийг гаргалаа.

Хурлын шийдвэр:

1. Компанийн 2016 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн гүйцэтгэлийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж, хангалттай гэж дүгнэлээ.
2. Компаний аудитын хорооны 2016 оны ажлын тайлан, дүгнэлтийг хэлэлцэж, хангалттай гэж дүгнэв.
3. Хөндлөнгийн аудитын компаниар "Далайван аудит" ХХК-г сонгож, нэг жилийн гэрээ байгуулан хамтран ажиллахаар шийдвэрлэв.
4. ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт, төсвийг хэлэлцэж, ТУЗ-ийн бүтэц бүрэлдэхүүнийг хэвээр нь ажиллуулахаар, ТУЗ-ийн төсвийг оруулсан саналаар батлав. ТУЗ-ийн хараат болон хараат бус гишүүдийг нэгдүгээр хавсралтаар, ТУЗ-ийн хороодын дарга, гишүүдийг хоёрдугаар хавсралтаар тус тус батлав.
5. Компаний санхүүгийн үйл ажиллагааны чадвараас хамаарч ноогдол ашиг хуваарилах боломжгүй гэж шийдвэрлэв.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ТАНИЛЦСАН:

ХУРЛЫН ДАРГА

Х.НАРАНТУЯА

Р. СҮМБЭНХҮҮ

